БАТЛАВ
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ЦЭРЭННАДМИД

АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР СУМЫН НУТАГТ ОРШИХ
"ТАЙХАР ЧУЛУУ" ОРЧМЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

\№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	• Монгол Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" • Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.6-д "Баян-Өлгий, Увс, Ховд Өвөрхангай, **Архангай**, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна". • Монгол Улсын Засгийн газрын 333 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийн Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх зорилтын 4.4.1 "Баруун бүсэд-адал явдалт, тусгай сонирхлын, **хангайн бүсэд**–байгалийн, амралт зугаалгын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийж, гол зорих газрууд, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хөгжлийн чиг хандлагыг бүсчлэн тодорхойлох" 4.4.2 "Байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлээр эко, тогтвортой аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож, хөгжүүлнэ". • Засгийн Газрын 2017 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан "Талын зам" үндэсний хөтөлбөрийн 4.1.4-т "Аялал жуулчлалын голлох бүс нутгуудад үндэсний парк, цогцолборыг байгуулж аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлснээр аялал жуулчлалын салбарт ажлын байр нэмэгдэж жуулчдын тоо өсөж салбарын эдийн засагт оруулах үр өгөөж нэмэгдэнэ" гэж тус тус заасан.
2.	Зориулалт, хүчин чадал (Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлөөр)	Тайхар чулуу орчмын газар ашиглалт нь дараах үндсэн бүсүүдээс бүрдэх бөгөөд төлөвлөлтийн явцад захиалагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ. Үүнд: - Амралтын газар - Худалдаа үйлчилгээний газар - Жуулчдад үйлчлэх хэсэг /нум сум харваа, морь сарлаг уналага/ - Отоглох бүсүүд - Эко гэр амралт /амралтын гэр/ Гадна талбайн зүлэг, цэцэрлэгжүүлэлт
3.	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ	Архангай аймгийн Ихтамир сумын Тайхар чулуу орчмын 10 га талбайд төлөвлөлт хийх. Ихтамир сумын төвөөс 4 км зайд оршдог.

4.	Зураг төслийн ажлыг боловсруулахад ашиглах материал	Монгол Улсын хуулиуд: - Барилгын тухай хууль - Хот байгуулалтын тухай хууль - Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль - Аж ахуй нэгж үйл ажиллагааны тусгай зөшөөрлийн тухай хууль: - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Аялал жуулчлалын тухай - Эрүүл ахуйн тухай хууль - Галын аюулгүй байдлын тухай - Усны тухай хууль Норм, норматив: - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм - БНбД 11-08-06. Барилгын геодезийн ажил - Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм 22-01-01/20068* - БНбД 11-104-06 Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил - Авто зогсоол /БНбД 21-05-10/ - БНбД 3.02.01.90 Барилгын газар шороо ба буурь суурийн ажил - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21.02.02/ - БНбД 3.01.06-90 Барилгын орчны тохижилтын ажил - БНбД 81-01-06 Газар шорооны ажил - БНбД 81-95-12 Төсөв зохиох дүрэм - БНбД 81-95-12*2020 төсөв дүрэм - БНбД холбогдох норм, дүрэм - Стандартууд - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6050:2003, 6055:2009/
5.	Зураг төсөл, баримт бичгийн иж бүрдэл	1. **Бэлтгэл ажил**: - Байр зүйн дэвсгэр зураг - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ - Инженер геологийн дүгнэлт **2. Баримт бичиг** - Аялал жуулчлалын бүс нутгийн алсын харааг тодорхойлох - Аялал жуулчлалын бүс нутгийн зорилгыг тодорхойлох - Аялал жуулчлалын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох **3. <u>Зураглан материал:</u>** - Байршлын схем - Орчны тойм - Аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг /М1:2000/ - Нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэлийн зураг /М1:5000/ - Газар зохион байгуулалт /М1:2000/ - Зам, тээврийн сүлжээ /М1:2000/ - Инженерийн дэд бүтцийн хангамж /М1:2000/ - Цэцэрлэгжилт, ногоон байгууламж /М1:2000/

		- Аялал жуулчлал, амралт зугаалгын нэгдсэн төлөвлөлт /М1:2000/ - Тайлбар бичиг - Товч танилцуулга - Зураг төслийг нутгийн иргэд, Ихтамир сумын удирдлагууд болон Тайхар чулуу орчим үйл ажиллагаа явуулж буй эсхүл төлөвлөж буй иргэн ААН үүдтэй хэлэлцүүлэн боломжтой саналыг тусгах.
6.	Онцгой нөхцөл	Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дэвсгэрт орших Тайхар чулуу орчимд иргэн аж ахуйн нэгжийн аялал, жуулчлалын чиглэлээр эзэмшиж ашиглаж буй болон тамирын голын сав газар, түүхийн дурсгалт газрын хамгаалалтын бүсийн нутаг дэвсгэр хамаарна. <u>Шийдвэрлэх үндсэн асуудал:</u> - Тухайн газар нутгийн байгаль экологийг хамгаалах, түүхийн болон орон нутгийн онцлог шинжийг тусгасан архитектур орон зайн төлөвлөлтийн шийдлийг, Тайхар чулууг түшиглэн нутгийн иргэдэд ажлын байр бий болгоход чиглэн боловсруулах; - Газар ашиглалтын үүрэг зориулалт, бүсчлэлийг тогтоох - Эко орчныг бүрдүүлэхэд анхаарч, олон давхар барилга байгууламжийг төлөвлөхгүй, байгалийн унаган төрхийг хадгалах; - Жилийн дөрвөн улирлын турш байнгын ажиллагаатай байх боломжийг судлан тусгах. <u>Төлөвлөлтөд тавигдах шаардлага:</u> - Зураг төслийн төсөв, нэгдсэн төсвийг зохиох эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программ ашиглан тооцох - Бусад норм, дүрэмд заасан шаардлагуудын хүрээнд төлөвлөх <u>Ногоон байгууламжид тавигдах шаардлага:</u> - Архитектур орон зайн төлөвлөлтөд нийцсэн ландшафтын шийдэл бүхий тохижилтын элементүүдийг явган зорчигчдын хөдөлгөөнд саад учрахгүй байхаар төлөвлөх <u>Түүх дурсгал:</u> - Тайхар чулуу орчим нь Тамирын голын ай сав бүхий байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнт газар оршдог - Аялал жуулчлалын цогцолборын тогтвортой үйл ажиллагааны менежментийг тодорхойлж, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцоолсон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, - Бусад норм, дүрэмд заасан шаардлагуудын хүрээнд төлөвлөх, - Судалгааны явцад шийдвэрлэх асуудлуудын хүрээнд зайлшгүй орох шаардлагатай чиглэлийг нэмж тодорхойлж гүйцэтгэх;
7.	Зураг төсөл боловсруулах	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр гүйцэтгэх хугацааг үндэслэл болгоно.

	хугацаа, үе шат	1 үе шаттай байна.
8.	Баримт бичиг боловсруулахад шаардлагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
9.	Захиалагч байгууллага	- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, - Архангай аймгийн ЗДТГ - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
10.	Тусгай зөвшөөрөл	- ХБ-1.2 Бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл - ХБ-1.1 Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө - ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээцийн зураг төсөл - ЗТ-4.8 Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл - ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв /тухайн ажлын төрлийн хүрээнд/
11.	Зөвшилцөх байгууллага	- Байгаль орчин, аялал жуулчлалын яам - Архангай аймгийн Засаг дарга - Архангай аймгийн Ерөнхий Архитектор - Аймгийн Онцгой байдлын газар - Ихтамир сумын Засаг дарга

ХЯНАСАН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА Ч.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Л.ДЭЛГЭРДАЛАЙ

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН
МЭРГЭЖИЛТЭН Л.ЛХАСҮРЭН

АРХАНГАЙ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

ОДООГИЙН БАЙДАЛ

ОДООГИЙН БАЙДАЛ

Тайхар чулуу
Taikhar Chuluu Rock
Google Earth
Image © 2025 Maxar Technologies
N
Legend
1000 ft